

ээгнэнхэн төрсөн хүн гэдгийг нэмэн хэлэх учиртай. Энэ бүхий чанараараа ардын хувьсгалын удирдагч байн байсаар байх тэр хүн Монголчуудын үндэсний бахархалын цогц бүрдэл, товчоо цомнол болж явна.

Цагт төрж, цагийг төрүүлсэн хүний хөрөг, цагийн холбоосын тухай анхны бодол ийм байна. Бодол үргэлжилсээр ...

ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНИКИЙН ДЭВШИЛ, БНМАУ ДАХЬ СОЦИАЛИСТ БАЙГУУЛАЛТ

Г. СҮРЭНЖАВ

Философийн ухааны дэд эрдэмтэн

Манай эрин үеийн нийгэм-түүхийн нэг гол үйл явц болсон шинжлэх ухаан-техникийн дэвшил (ШУТД) нь нийгмийн амьдралын бүх талд нөлөөлөн улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасгах нэг чухал хөшүүрэг болохын зэрэгцээгээр эргээд түүний хөгжлийн тодорхой түвшингээр нөхцөлдөн тодорхойлогддог билээ. Улс орны социалист байгуулалт гүнзгийрэхийн хэрээр нийгмийн үйлдвэрлэлийн өмнө ШУТД тэй нягт холбоотойгоор шийдвэрлэвэл зохих өргөн цар хүрээтэй асуудал дэвшин гарч байгаа нь түүний хөгжлийн диалектик юм. В. И. Лениний зааж хэлсэнчлэн хамгийн шинэ шинжлэх ухааны сүүлчийн ололтууд дээр үндэслэн байгуулсан техникгүйгээр социализмын тухай сэтгэшгүй юм.¹

Тус орны социалист байгуулалтын цар хүрээ өргөжихийн хэрээр ШУТД нь нийгмийн амьдралын бүх салаа салбарт нэвтэрч тэдгээртэй улам бүр холбоо харилцаатай болж буй одоо үед нийгмийн хөгжлийн аливаа асуудлыг энэхүү дэвшлээс салгаж үзэхийн нөхцөлгүй юм. Энэ ч учраас МАХН-ын XIX их хурлаас «Шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглахтай холбогдолгүй шийдэх үйлдвэрлэлийн болон нийгмийн нэг ч асуудал байхгүй»² гэж онцлон заалаа.

МАХН-ын программ болон сүүлийн үеийн бусад баримт бичигт ШУТД-ийг цаашид өрнүүлэх үйл явцыг авч үзэхдээ шинжлэх ухаан техникийн болон нийгмийн хөгжлийн холбоо харилцаанаас урган гарч буй эл шаардлагыг гүнзгий тусгасан иж бүрэн зорилтууд дэвшүүлэн тавьсан юм. Шинжлэх ухаан-техникийн болон нийгмийн хөгжил, тэдгээрийн холбоо харилцааг шинжлэх ухааны үүднээс танин мэдэж, хөгжилд нь идэвхтэй нөлөөллийг үзүүлж, ухамсартай, чиглэсэн зорилготой гоор удирдан чиглүүлэх явдал ШУТД-ийн зүй тогтолт хандлага, түүний нийгэм-эдийн засгийн үр дагаврыг нарийвчлан судлахыг зүй ёсоор нөхцөлдүүлж байна. Энэ ч учраас одоо социалист орнууд, ялангуяа ЗХУ-д ШУТД-ийг хурдасгах нийгэм-эдийн засгийн асуудлуудыг судлан боловсруулах явдал нийгмийн шинжлэх ухааны судалгааны нэгэн

тэргүүлэх чиглэл болж, энэхүү дэвшлийн онол, практикийн чухал чухал асуудлаар иж бүрэн судалгаа явуулж байна.

Шинжлэх ухаан, техникийн хөгжлөөр хоцрогдонгуй Монгол орны нөхцөлд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололт, үр дүнг бүтээлчээр ашиглах, ШУТД-ийг цаашид өрнүүлэх чиглэл, арга замыг тодорхойлох, түүний нийгэм-эдийн засгийн үр дагавар зэрэг асуудлыг философи, эдийн засгийн үүднээс нарийвчлан судлан шийдвэрлэх нь онол арга зүйн төдийгүй, практикийн ач холбогдол бүхий тулгам зорилтын нэг болж байна,

Монгол оронд ШУТД өрнөхдөө социализмын замд орсон ах дүү орнуудын нэгэн адил түгээмэл зүй тогтлоор явагдахын зэрэгцээгээр тус орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн түүхэн тодорхой нөхцөл байдал, ялангуяа үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, Нийгмийн харилцааны төгөлдөржилтийн хэр хэмжээтэй нягт уялдан өвөрмөц онцлог шинжүүдтэй байгаа нь зүйн хэрэг.

БНМАУ-ыг социалист ёсоор үйлдвэржүүлэх явцад дараахь өвөрмөц онцлог илэрч байна. **Нэгдүгээрт**, хоцрогдсон хөдөө аж ахуйн оронд аж үйлдвэрийг бүхэлд нь шинээр үүсгэн бий болгосон, **хоёрдугаарт**, үйлдвэржүүлэлт нь хүнд аж үйлдвэрээс биш, харин хөдөө аж ахуйн түүхий эдийн баазад тулгуурлан хөнгөн, хүнсний аж үйлдвэрийг байгуулахаас эхэлсэн юм. **Гуравдугаарт**, машин техникийн баазад тулгуурлан социалист ёсоор үйлдвэржүүлэх явцад ШУТД-ийн гол субъект болсон үндэсний ажилчин анги, инженер-техникийн ажилтан бий болж төлөвшсөн нь энэхүү дэвшлийн өвөрмөц онцлог шинжийг илэрхийлж байна.

Нам, засгаас явуулсан зөв бодлого, арга хэмжээний үрээр ЗХУ болон ах дүү бусад орны тусламжинд тулгуурлан аж үйлдвэр, механикжсан газар тариалан зэрэг материаллаг үйлдвэрлэлийн салбар үүсч байгуулагдахын зэрэгцээ энэхүү машин техникийг эзэмшин ажиллуулах чадвар бүхий ажилчин анги, сэхээтэн, түүний дотор үйлдвэрлэл-техникийн сэхээтэн бий болж төлөвшив. Чухамдаа БНМАУ-д машинт үйлдвэрлэл бий болсноор биологийн шинжтэй эрчим хүчний эх сурвалжид тулгуурласан гар хөдөлмөрийн энгийн багаж зэвсэг орчин үеийн гурван хэсэгт машинаар солигдож, феодализмаас уламжлан үлдсэн техникийн хоцрогдсон бааз хувьсгалжин өөрчлөгдөж, улмаар улс орны нийгмийн үйлдвэрлэлийн техник технологийн хөгжилд үндсэн эргэлт гарсан юм. Ийнхүү тус орон дахь техникийн дэвшлийн мөн чанар нь гар хөдөлмөр механикжсан машинт хөдөлмөрөөр улам бүр солигдож байгаагаар илэрч байна.

БНМАУ нийгмийн хэрэгцээ, эх орны шинжлэх ухаан-техникийн потенциалын бололцоо, хэр хэмжээг үндэс болгон орчин үеийн шинжлэх ухааны бүхий л салбарыг биш, харин тодорхой чиглэл, салбарыг сонгон авч хөгжүүлж ирэв. Ардын хувьсгалын дараа Монгол оронд нийгмийн ухаан эхлэн хөгжиж, дараа нь материаллаг үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагаар хөдөө аж ахуй, мал эмнэлэг, анагаах ухаан, мөн түүнчлэн биологи, геологи, газар зүй хими, физик зэрэг байгалийн ухааны салбарууд хөгжиж эхлэв. Улс орны социалист байгуулалт, үйлдвэржүүлэлт гүнзгийрэх явцад материаллаг үйлдвэрлэлийг цаашид хөгжүүлэх үйлдвэрлэл-техникийн хэрэгцээ, эх орны шинжлэх ухааны хөгжлийн дотоод зүй тогтолтой нягт уялдан 1960-аад оноос байгаль, нийгмийн ухаан эрчимтэй хөгжихийн зэрэгцээ техникийн

ухааны зарим салбар бий болон хөгжиж, ингэснээрээ тус орны үйлдвэр дэх хүч, соёлыг хөгжүүлэх үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байна. БНМАУ-ын туршлагаас үзэхэд, эх орны шинжлэх ухааны хөгжлийн эхний шатанд орчин үеийн шинжлэх ухааны ололтыг тус орны байгаль цаг уурын өвөрмөц онцлог нөхцөл болон нийгэм-эдийн засгийн хөгжлийн түүхэн тодорхой бодит байдалд бүтээлчээр хэрэгжүүлэхэд чиглэсэн хавсрага судалгаа, боловсруулалт голлон хөгжиж байсан бөгөөд харин сүүлийн үед онол-эрэл хайгуулын шинжтэй суурь судалгаа өргөжин хөгжиж эхлэв. Судалгааны төрлүүд ийм дэс дараалалтай хөгжиж буй нь техникийн хувьд хоцрогдмол байсан улс орнууд, тухайлбал хөгжлийн капиталист шатыг алгассан БНМАУ-д Шинжлэх ухааныг хөгжүүлэх зүй тогтолт хандлага юм.

Тус оронд орчин үеийн техник, технологи бүхий аж үйлдвэрийн шинэхэн газруудыг байгуулах, бүхэлдээ үйлдвэрлэлийн техникжилтийн түвшинг дээшлүүлэх замаар социалист үйлдвэржүүлэлтийг гүнзгийрүүлэх, шинжлэх ухаан-техникийн хувьсгалын ололтыг эзэмших үйл явц зэрэгцэн хэрэгжиж байгаа нь энэхүү дэвшлийн нэг онцлогийг илэрхийлж байна. Анх үйлдвэр, техникийн хувьд хоцрогдсон феодализмаас социализмд шилжин орсон Монгол оронд Шинжлэх ухаан-техникийн дэвшлийг тодорхойлогч салбарууд болох төмөрлөг, машин, цахилгаан техник, химийн аж үйлдвэр төдийлөн хөгжөөгүй байгаа нөхцөлд зөвхөн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан энэхүү дэвшлийг өрнүүлэх обьектив нөхцөл бүрдүүлэх нь ихээхэн хөрөнгө хүч, цаг хугацаа шаардагдах бэрхшээлтэй зүйл юм. Энэхүү бэрхшээлийг гэтлэн давах арга зам бол социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хүрэн дэх ШУТД-ийн зохистой нөлөөг хүлээн авах, тухайлбал тэдгээр орны тэргүүний техник, технологийг нийгмийн үйлдвэрлэлд өргөн нэвтрүүлэх явдал мөн. Тус орны түүхэн хөгжлийн одоогийн шатанд ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орны төмөрлөг, машин, цахилгаан техник, электроник, химийн зэрэг аж үйлдвэр нь БНМАУ дахь шинжлэх ухаан-техникийн дэвшлийн тодорхойлогч салбаруудын үүргийг нөхөн гүйцэтгэж байгаагаараа онцлог шинжтэй юм.

БНМАУ-д ШУТД-ийг цаашид түргэтгэх асуудлыг авч үзэхдээ тус орны нийгмийн хөгжлийн түүхэн тодорхой байдлын зэрэгцээ басхүү Социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хамтын ажиллагаатай холбож үзэх нь зүйн хэрэг. Социалист орнууд, ялангуяа ЗХУ-тай шинжлэх ухаан, техникийн салбарт тогтоосон нягт хамтын ажиллагаа, түүний шинэ шат болсон, социалист интеграц нь манай орны ШУТД-ийн цаашдын өрнөлтөд хэтийн сайхан төлөв нээж байна. Чухамхүү энэ амьд холбоо л тус оронд шинжлэх ухаан, техникийг эрчимтэй хөгжүүлэх, орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололтыг нийгмийн үйлдвэрлэлд нэвтрүүлэн эзэмших чухал хүчин зүйл мөн.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын ШУТД-ийн 2000 он хүртэлх цогцолбор программд тодорхойлсон улс ардын аж ахуйг электронжуулах, үйлдвэрлэлийн үйл явцыг автоматжуулах, атомын эрчим хүчийг ашиглах, шинэ нэр төрлийн материал буй болгож, түүнийг үйлдвэрлэх шинэ технологи боловсруулах, биотехнологийн аргыг нэвтрүүлэх зэрэг энэхүү дэвшлийн тэргүүлэх чиглэлээр явуулах хамтын судалгаанд БНМАУ идэвхтэй оролцож гарсан үр дүн, ололтыг өөрийн орны өвөрмөц нөх цөлд бүтээлчээр хэрэглэх бололцоо нь манайд өрнөж буй ШУТД-ийн дотоод тал, харилцаагаар дамжин, тухайлбал субъектив хүчин зүй-

лийн элемент болох хүмүүсийн мэдлэг чадвар, идэвхтэй үйл ажиллагаагаар бодит үйл хэрэг болдог билээ. Иймд юуны өмнө дээрх тэргүүлэх чиглэлүүдээр гарсан ололт, амжилтыг хүлээн авч бүтээлчээр хэрэгжүүлэх чадвар бүхий өндөр мэргэшлийн боловсон хүчнийг бэлтгэх явдал эн тэргүүний зорилт мөн.

ШУТД-ийг нийгмийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх чухал хөшүүрэг болгон хувиргахад социализмын давуу талыг бүтээлчээр ашиглах явдал нь улс орны социалист байгуулалтаар дэвшин гарч буй зүй тогтолт үйл явц юм. МАХН-ын программд: «аж үйлдвэрийн материал-техникийн баазыг өргөтгөн хөгжүүлэх, хөдөлмөрийг механикжуулах хэмжээг дээшлүүлж, үйлдвэрлэлийн ажиллагааг аажмаар автоматжуулах, үйлдвэрлэлийн технологи, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох»³ талаар заасан зорилт хэрэгжиж, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн үндсэн үйл явц «өргөн тийшээ» механикжихын зэрэгцээ «гүн тийшээ» механикжиж байна. Техникийн дэвшлийг тодорхойлогч нэг үндсэн үзүүлэлт болох үйлдвэрлэлийн үйл явцын механикжилтын коэффициент эрчим хүчний аж үйлдвэрт 90 гаруй хувь, уул уурхайн аж үйлдвэрт 80 гаруй хувь, хөнгөн, хүнсний аж үйлдвэрт 60—90 хувьд хүрчээ. Мөн барилгын үндсэн ажлын механикжилтын коэффициент газар шорооны ажилд 95 хувь, ачих буулгах ажилд 80 гаруй хувь, бетон угсрах ажилд 97,3 хувь, бетон зуурмаг бэлтгэх ажилд 93,3 хувь болжээ.

Тус орны үйлдвэрлэх хүчний бүрэлдэхүүнд хөдөлмөрийн механик хэрэгсэл (төрөл бүрийн машин, механизм) нэвтэрч, цахилгаан станц, хөдөлгүүр хэрэглэх болсоноор эрчим хүчний гол эх сурвалж нь малын зүтгэх хүч, хүний булчингийн хүч бус, харин механик хөдөлгүүрийн болон цахилгаан эрчим хүч болж хувирав. 1970—1985 онд хөдөлмөрийн цахилгаан зэвсэгжилт аж үйлдвэрт 3,2 дахин, барилгад 7,8 дахин, хөдөө аж ахуй, ойн аж ахуйд 5,6 дахин, тээвэр холбоонд 2,9 дахин нэмэгдэв.⁴

Улс орны нийгмийн үйлдвэрлэлийн механикжилтын түвшин дээшлэхийн зэрэгцээ ердийн машин автомат машинаар солигдох үйл явц аажим явагдаж байна. Ялангуяа эрчим хүч, уул уурхай, хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн үйлдвэрлэлд автомат шугам, автомат техник нэвтэрч үйлдвэрлэлийн зарим үйл явц хэсэгчлэн автоматжиж байгаа юм.

Ийнхүү гар хөдөлмөрийн энгийн багаж зэвсэг гурван хэсэгт машинаар солигдсоноор хүний үндсэн үүрэг болж байсан гар хөдөлмөрийн багаж зэвсгийг шууд удирдах үүргүүд ажлын машинд шилжиж, улмаар үйлдвэрлэх хүчний бие хүний болон эдлэг элементийн хооронд шинэ маягийн холбоо харилцаа бүрэлдэн тогтсон бөгөөд чухамхүү хүн, техник хоёрын холбооны энэ шинэ хэв маяг нь хүн машины системийг удирдан ажиллуулах шинэ үүрэгтэй болсноор тодорхойлогдож байна. Гар хөдөлмөр механикжсан хөдөлмөрөөр солигдсоноор гар хөдөлмөрт тулгуурласан үйлдвэрлэлийн технологи арга нь машинт хөдөлмөрт тулгуурласан үйлдвэрлэлийн технологи аргад шилжив. Чингэж үйлдвэрлэлийн технологийн үйл явц дахь хүний байр суурь, гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөж, хүн-техник» гэсэн системд чанарын өөрчлөлт гарч шинэ байдал бий болж байгаа нь Монгол оронд өрнөж буй ШУТД-ийн нийгмийн нэн чухал үр дүн мөн.

Нийгмийн үйлдвэрлэлийн нийгэмжилт нь зөвхөн техникийн дэвшилтэй салшгүй холбоотой төдийгүй, шинжлэх ухааны хөгжилтэй нягт

холбоотойгоор гүнзгийрдэг бөгөөд энэ нь шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоогоор илэрдэг билээ. Тус оронд шинжлэх ухааны үйл ажиллагаа төрөлжин хөгжиж, эрдэм шинжилгээ, сорил туршилтын болон төсөл-зохион бүтээх байгууллагууд бий болж, тэдгээрийн судалгаа, боловсруулалтын үр дүнгүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа нь шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хооронд хийгээд үйлдвэрлэгчдийн болон эрдэм шинжилгээний ажилтнуудын хооронд шинэ тутам тогтож буй нийгмийн холбоог хүчтэй болгоход хүргэв. Тухайлбал, VII таван жилд салбарын эрдэм шинжилгээний байгууллагууд аж ахуйн тооцоонд шилжин ажиллаж, нийт зардлынхаа 70 гаруй хувийг, үүний дотор материаллаг үйлдвэрлэлийн салбарын эрдэм шинжилгээний байгууллагууд 90 гаруй хувийг орлогоороо нөхөв. Аж үйлдвэрийн салбарт дэвшилт технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн процессыг механикжуулах, автоматжуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэмших зэрэг мянга шахам арга хэмжээг VII таван жилд хэрэгжүүлж 100 гаруй сая төгрөгийн ашиг хуримтлал бий болгов. Малын үүлдэр угсааг сайжруулан ашиг шимийг дээшлүүлэх, хөдөө аж ахуйн тарималын үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар ахиц гарав. Эрдэм шинжилгээний ажилд ахиц гарч байгаа боловч улс ардын аж ахуйн хөгжлийн гол гогцоо асуудлыг иж бүрнээр судлан боловсруулж, практикт дорвитой нөлөө үзүүлэхүйц ажил цөөн байгаа бөгөөд үүний улмаас эх орны шинжлэх ухаан нийгмийн үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээг хангах, түүний хөгжилд шийдвэрлэгч нөлөө үзүүлэх хэмжээнд хүрээгүй байгаа юм. Энэ нь **нэгдүгээрт**; суурь, хавсрага ухааны ихэнх салбарууд шинэ тутам хөгжиж байгаагийн улмаас эрдэм шинжилгээний ажлын онол-аргазүйн болон сорил-туршилтын түвшин, өндөр мэргэшлийн боловсон хүчний хангамж, дадлага туршлага, зохих шаардлагын хэмжээнд хүрээгүй, **хоёрдугаарт**: Шинжлэх ухаан-техникийн дэвшлийн ололтыг социализмын давуу талтай холбох механизм болсон «Шинжлэх ухаан-үйлдвэрлэл» гэсэн системийн бүрэлдүүн хэсгүүдийн уялдаа холбоо, харилцан нөлөөлөл сул, зарим хэсэг нь шинэ тутам үүсч байгаа, тухайлбал шинжлэх ухааныг үйлдвэрлэлтэй холбох чухал шижим болох техник, технологийн боловсруулалтын шат, хагас үйлдвэрлэлийн туршилт хийх нэгж эхлэлийн төдий хөгжиж байгаа, **гуравдугаарт**; шинжлэх ухаан, техникийн ололт, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд шилжүүлэх, нэвтрүүлэх зохистой систем тогтож, түүний механизм боловсронгуй болоогүй, **дөрөвдүгээрт**; шинжлэх ухаан, техникийн талаар хөгжингүй социалист орнуудад нэгэнт үр дүнтэйгээ харуулсан шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбооны зохион байгуулалтын оновчтой хэлбэрүүдийг сонгон авч тус оронд бүтээлчээр хэрэгжүүлэх үйл явц удаашралтай байгаа зэрэгтэй шууд холбоотой юм.

Энэ учраас МАХН-ын XIX их хурал эх орны шинжлэх ухаан, техникийн хөгжлийн одоогийн байдлыг дүгнэн үзээд ШУТД-ийг нийгмийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх нэг хөшүүрэг болгохын үүднээс шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог шинэ шатанд гаргах зорилтыг дэвшүүлэн тавилаа.

Эх орны шинжлэх ухааныг эрчимжүүлэн хөгжүүлж, нийгмийн ач холбогдлыг нь эрс дээшлүүлэх шаардлагын үүднээс юуны өмнө шинжлэх ухааны зохион байгуулалтын бүтэц хийгээд түүнийг үйлдвэрлэлтэй холбох нийгэм-эдийн засгийн механизмыг өөрчлөн боловсронгуй

болгох, тухайлбал нэг талаас улс ардын аж ахуйн салбаруудад дэвшилтэт техник, технологи өргөн нэвтрүүлэхэд чиглэсэн боловсруулалт хийх чадвар бүхий салбар дундын томоохон лаборатори, Шинжлэх ухаан-техникийн цогцолбор, төв, мөн зарим үйлдвэрийн нэгдлийг түшиглэн үйлдвэрлэлийн нийгэмчлэлтийн нэн чухал хандлага болсон шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн нэгдэл, эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн хамтлаг байгуулах зэрэг хэлбэрийг үр бүтээлтэй, оновчтой ашиглах, нөгөөтэйгүүр, шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд шуурхай нэвтрүүлэхэд түлхэц болохуйц аж ахуйн механизм, нийгэм-эдийн засгийн урамшууллын систем тогтоож хэрэгжүүлэх нь чухал байна. Энэ нь шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нийгэмчлэлтийг гүнзгийрүүлэн, улмаар тэдгээрийн хооронд чанарын шинэ холбоо бүрэлдэн тогтоход хүргэнэ. Ийнхүү шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нийгэмчлэлийн цаашдын хөгжил нь үйлдвэрлэлийн ажилтнуудын үйлдвэрлэх хүчийг шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ажилтнуудын хамтын шинэ үйлдвэрлэх хүч болгоно. Энэхүү шинэ үйлдвэрлэх хүч нь орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн шинжлэх ухааны нийгмийн ач холбогдлыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд энэ үндсэн дээр шинжлэх ухаан үйлдвэрлэх хүч болж хувирах үйл явц түргэсэх болно.

Нийгмийн үйлдвэрлэх хүчний динамикт гарсан тоо, чанарын өөрчлөлт нь ШУТД-ийн нөлөөн дор материаллаг үйлдвэрлэл, ялангуяа аж үйлдвэрийн салбаруудын фонд зэвсэглэмж, хөдөлмөрийн бүтээмж өсөж байгаа хийгээд улс ардын аж ахуйг мэргэжилтэй ажиллах хүчнээр хангах хэмжээ хэлбэрэлтгүй дээшилж байгаагаар илэрч байна. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт нь үйлдвэрлэх хүчний динамик өөрчлөгдөж буйн шалгуур, түүний хөгжилд ШУТД-ийн үзүүлэх нөлөөний гол чиглэл мөн. Хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлт нь шинэ техник, технологид тулгуурласан үйлдвэрлэлийн техник хэрэгслийн хөгжлөөр нөхцөлддөг. Энэ учраас К. Маркс: «Машин бол хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хамгийн хүчирхэг хэрэгсэл мөн»⁵ гэж тэмдэглэжээ.

Үйлдвэрлэлийн энгийн багаж зэвсгээс машинт үйлдвэрлэлд шилжсэнээр манай нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн динамик өсөлтөд үсрэлт гарав. Эл үсрэлт нь тус орны үйлдвэрлэх хүчний хөгжилд гарсан чанарын шинэ шатны интеграл үзүүлэлт юм. Үйлдвэрлэлийн механикжилт, автоматжилтын түвшин дээшилж, шинэ техник, технологи, шинжлэх ухааны үндэстэй хөдөлмөр зохион байгуулалт нэвтрэх тутам хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн багаж зэвсэгт гарсан техникийн дэвшлийн үр дагавар мөн юм. Манай хөдөлмөрийн механикжилт, техникжилтын түвшин дээшлэн, тухайлбал аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын фонд зэвсэглэмж 1985 онд 1960 оныхоос 4,4 дахин өссөн байхад хөдөлмөрийн бүтээмж нь 2,8 дахин, түүний дотор аж үйлдвэрт фонд зэвсэглэмж 9,6 дахин өссөн байхад хөдөлмөрийн бүтээмж 3,3 дахин өсчээ. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт нь зарим салбарт фонд зэвсэглэмжийн өсөлтөөс хоцрогдонгүй байгаа нь манайд «хүн-техник» гэсэн системийн хүрээнд үйлдвэрлэлийн техник, түүний ашиглалтын хооронд буюу нэг талаас техникийн дэвшлийн түвшин, шинж, нөгөө талаас бие хүний чадвар, техникийн мэдлэг, мэргэжлийн харьцангуй хоцрогдлын хооронд зөрчил байгаатай холбоотой юм. Энэхүү зөрчлийг шийдвэрлэгч гол субъект нь хүн мөн. Эл учир бие хүний бүх талын чадвар,

соёл-техникийн мэдлэгийн түвшин, ялангуяа техник-мэргэжлийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх нь өнөө үед хүн-техник» гэсэн системийн дотоод зөрчлийг шийдвэрлэх нэн чухал хүчин зүйл болж байна.

Социализмын нөхцөлд хөдөлмөрчин олон түмнийг шинжлэх ухаан техникийн бүтээлд өргөнөөр татан оролцуулах бололцоотой бөгөөд чухамхүү үүгээр ШУТД-ийн нэг онцлог, социалист нийгмийн хөгжлийн давуу тал илэрч байна. ШУТД-ийг түргэтгэхэд хүний хүчин зүйлийн өсөлт, юуны өмнө олон түмний хөдөлмөрийн бүтээлч идэвх, авъяас чадвар, үүсгэл санаачлагын хөгжил нь энэхүү давуу талаар тодорхойлогдоно.

Социалист нийгэмд олон түмний хөдөлмөрийн бүтээлч идэвхийн хөгжил ШУТД-ийг цаашид өрнүүлэх чухал нөхцөл болдог билээ. Энэхүү дэвшил нь хөдөлмөрийн механикжилт, автоматжилтын түвшинг дээшлүүлэхэд үлэмж нөлөө үзүүлснээр хөдөлмөрийн бүтээлч идэвх, авъяас чадвар, үүсгэл санаачлага илрэх бололцоог өргөжүүлээд зогсохгүй, харин тэдгээрийг цаашид хөгжүүлэхийг шаарддаг. Шинэ техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эзэмших, түүнийг боловсронгуй болгох нь олон түмний бүтээлч идэвхийн өсөлт, ялангуяа шинийг санаачлагчид, шинэ бүтээл, оновчтой санал (ШБОС) гаргагчид түүнд идэвхтэй оролцохоос үлэмж шалтгаална.

Техникийн бүтээл бол олон түмний хөдөлмөрийн бүтээлч идэвхийн илрэх хэлбэр, түүний хөгжлийн нэн чухал үзүүлэлт юм. Бүтээлч хөдөлмөрийн үзүүлэлт болох ШБОС нь техникийн бүтээлийн дээд хэлбэр мөн, Нийгмийн үйлдвэрлэлийн механикжилт, автоматжилтын түвшин дээшлэх тутам үйлдвэрлэл-техникийн хувьд шийдвэрлэвэл зохих нарийн асуудал дэвшин гарч, ялангуяа үйлдвэрлэлийн бүтээлч сэтгэлгээ болох ШБОС-ын үйл ажиллагаа улам бүр өрнөж, түүнд ахиц гарч байна. ШБОС-ын үйл ажиллагаа урьд өмнө хаягдал ашиглах, түүхий эд, материал хэмнэх, үйлдвэрлэлийн зарим нэг шат дамжлагыг өөрчлөхөд голлон чиглэж байсан бол сүүлийн үед нарийн ажиллагаатай машин, тоног төхөөрөмж, микропроцессорын байгууламж бүхий электрон багаж хэрэгсэл, аппарат зохион бүтээж, үйлдвэрлэлийн бүхэл бүтэн дамжлага хэсгийг өөрчлөн сайжруулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулах зэргээр техник, технологийн иж бүрэн шинжтэй бүтээл, санал гаргахад чиглэж, ШБОС-ын дотор шинэ бүтээлийн эзлэх хувь нэмэгдэв. Тухайлбал, VII таван жилд шинийг санаачлагчдын тоо 2,2 дахин, батлагдсан шинэ бүтээлийн тоо 2,7 дахин, тэдгээрийг үйлдвэрлэлд нэвтрүүлснээс олсон эдийн засгийн үр ашиг 2,8 дахин өсчээ. Энэ нь тус орны шинжлэх ухаан-техникийн сэтгэлгээний өнөөгийн хөгжлийн хэр хэмжээг харуулах нэг үзүүлэлт болж улмаар ШБОС улам бүр олон нийтийг хамарсан, хамтын шинжтэй болж байгаа явдал хөдөлмөрчдийн техникийн бүтээлийн нэг онцлог, түүний цаашдын хөгжлийн гол хандлага болж байна.

1 В. И. Ленин, Зохиолууд 27-р боть, 357 дахь тал

2 Ж. Батмөнх, Монгол Ардын Хувьсгалт Намын XIX их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан, цаашдын зорилт, УБ, 1986, 41 дэх тал

3 Монгол Ардын Хувьсгалт Намын программ, УБ, 1966, 19 дэх тал.

4 БНМАУ-ын Улс ардын аж ахуй 65 жилд (статистикийн эмхэтгэл) УБ, 1986, 46 дахь тал

5 К. Маркс и Ф. Энгельс. Соч., т. 23, с. 414